



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/81

Хархорин сум

**Мал, амьтны гоц халдварт "Шүлхий" өвчнөөс
урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/126 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батчулуун (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ц.Пүрвээ ("Дэлийн бүрд" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч)

А.Сайнбилэг ("Аяган зураа" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч)

Б.Нямсүрэн ("Өвдөлгөөн ундарга" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч)

Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)

Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)

Д.Гантөмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Ө.Энхжаргал (4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)

Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)

О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)

Ц.Гомбосүрэн (8 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Тархвар зүйч)

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 28-ны хооронд зохион байгуулахыг "Дэлийн бүрд", "Аяган зураа", "Өвдөлгөөн ундарга" мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай.

401100161

3.Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулж, барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт үүрэг болгосугай.

5.Шүлхий өвчний дархлаажуулалтад хамрагдах үхэр, тугал, гахайны судалгааг гарган, төлөвлөгөөг мал эмнэлгийн нэгдсэн системд оруулах, дархлаажуулалтын гүйцэтгэлд хяналт тавин тухай бүр гарсан зөрчлийг Мал эмнэлгийн газрын хяналтын улсын байцаагчид тухай бүр мэдэгдэн ажиллахыг мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Э.Нарангарав)-т даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (Д.Батчулуун)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ